



НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/ЧБ

Улаанбаатар хот

Нийслэл, дүүргийн оны “Тэргүүний
биеийн тамир, спортын хамтлаг”
шалгаруулах арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дэргэдэх Биеийн тамир, спортын хамтлагуудын үйл ажиллагааны тайлан үр дүнг үндэслэн Нийслэл, дүүргийн 2024 оны “Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг”-уудыг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Нийслэл, дүүргийн 2024 оны “Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг” шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 4,150,000 (дөрвөн сая нэг зуун тавин мянган) төгрөгийг Нийтийн биеийн тамирын зардлаас гаргахыг Нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй

4.Шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалын хавсралт



Нийслэл, дүүргийн 2024 оны
“Тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг”
шалгаруулах арга хэмжээний төсөв

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/	
1.	Шилдэг хамтлагийн шагнал	1-р байр	2	500,000	1,000,000
		2-р байр	2	400,000	800,000
		3-р байр	2	200,000	400,000
2.	Карказ, үзель, чимэглэл	-	-	950,000	
3.	Заал талбайн түрээс	-	-	1,000,000	
ДҮН				4,150,000	